



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдийн өргөөнд иргэн, цэргийн алба хаагч, гадаадын зочин, төлөөлөгчийг оруулах журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 126 дугаар зарлигийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдийн дүрэм”-ийн 12 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдийн өргөөнд иргэн, цэргийн алба хаагч, гадаадын зочин, төлөөлөгчийг оруулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/317 дугаар “Журам батлах тухай” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга бөгөөд Их Хар Сүлдийн сүлдэч /бригадын генерал Ц.Жавхланбаатар/-д даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100263

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
05 дугаар сарын 12-ны өдрийн
Амг дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛДИЙН ӨРГӨӨНД
ИРГЭН, ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ, ГАДААДЫН ЗОЧИН, ТӨЛӨӨЛӨГЧИЙГ
ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь иргэн, цэргийн алба хаагч, гадаадын зочин, төлөөлөгчийг Бүх Цэргийн Их Хар Сүлдийн өргөө /цаашид “Сүлдийн өргөө” гэх/-нд зочлуулж, Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдэд хүндэтгэл үзүүлэх, монгол цэргийн түүх, Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлд, Сүлдийн өргөөг сурталчлан таниулах, иргэнд эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд оршино.

1.2. Монгол Улсын иргэн /16 нас хүрсэн/, Төрийн цэргийн байгууллагын цэргийн алба хаагч, Батлан хамгаалах яам /БХЯ/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /ЗХЖШ/-т айлчилсан гадаадын өндөр хэмжээний зочин, төлөөлөгчид /цаашид “зочин, төлөөлөгч” гэх/ Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдэд хүндэтгэл үзүүлэх, Сүлдийн өргөөтэй танилцахад энэхүү журмыг баримтална.

Хоёр. Сүлдийн өргөөнд зочин оруулах өдөр

2.1. Сүлдийн өргөөнд орж Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдэд хүндэтгэл үзүүлэх өдрийг жил бүрийн Монгол цэргийн өдөр буюу 3 дугаар сарын 18, Монгол Улсын Төрийн далбааны өдөр буюу 7 дугаар сарын 10, Эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдрүүдээр тогтоож, зочныг өргөөнд оруулна. Эдгээр өдрүүдэд цэргийн алба хаагчид зохион байгуулалттайгаар Сүлдийн өргөөнд орж хүндэтгэл үзүүлж болно.

2.2. Гадаадын зочин, төлөөлөгч, төрийн цэргийн болон иргэний байгууллагын төлөөлөгч, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчийг сар бүрийн билгийн тооллын бар, луу, нохой өдрийн аль нэгийг сонгон зохион байгуулалттайгаар Сүлдийн өргөөнд оруулна.

2.3. Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдийн цагаалах тайлгын үед буюу билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн гуравны өдөр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлал, Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар болон Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллагын удирдах бүрэлдэхүүнийг Их хар сүлдийн тайлгын үйл ажиллагаанд оролцуулна.

Гурав. Сүлдийн өргөөнд зочин оруулах дэг

3.1. Сүлдийн өргөөнд нэвтрүүлэхийн урьд өргөөний хаалганы өмнө байрлуулсан хоёр галт бамбарын дундуур оруулна.

3.2. Зочныг өргөөний хаалгаар орсны дараа Бүх Цэргийн Их Хар Сүлдэд цэргийн алба хаагч ёсолж, иргэн толгой мэхийн хүндэтгэл үзүүлнэ.

3.3. ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бөгөөд Их сүлдэчийн зөвшөөрснөөр Сүлд хамгаалагчийн хяналт дор Их сүлдэчээс тусгайлан томилгоожсон элч сүлдийн сүлдэч нь зочинд Их Хар Сүлд, Элч Сүлдүүдийн талаар өргөөний үүдэн хэсэгт танилцуулж, улмаар зочныг Их Хар Сүлдийн өргөөний дотор баганыг тойруулан татсан гинжин хаалтын гадуур нар зөв тойруулан дагуулж, түүхэн танилцуулгыг хийнэ.

3.4. Бүх Цэргийн Их Хар Сүлдээс зочин адис авах тохиолдолд малгай авч, цэргийн алба хаагч баруун өвдөг дээр, иргэн хоёр өвдөг дээр сөхрөн сууж хадгаас адис авна.

3.5. Гадаадын зочин, төлөөлөгчид Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдэд зөвхөн толгой мэхийн хүндэтгэл үзүүлнэ.

3.6. Сүлдний өргөөнөөс гарахын өмнө Монгол Улсын Бүх Цэргийн Их Хар Сүлдэд цэргийн алба хаагч ёсолж, иргэн толгой мэхийн хүндэтгэл үзүүлсний дараа гарна.

Дөрөв. Сүлдийн өргөөнд гадаадын зочин, төлөөлөгчийг нэвтрүүлэх, урьдчилсан захиалга өгөх, хувцаслалт

4.1. Гадаадын зочин, төлөөлөгчийг Сүлдийн өргөөнд нэвтрүүлэх үйл ажиллагааг Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын урилгаар айлчлан ирсэн гадаадын зочин, төлөөлөгчийг хүлээн авах айлчлалын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

4.2. Төрийн цэргийн болон иргэний байгууллагын төлөөлөл Сүлдийн өргөөнд орох захиалгыг 3-аас доошгүй хоногийн өмнө Зэвсэгт хүчний Жанжин штабт өгнө.

4.3. Сүлдийн өргөөнд орох зочин ёслолын, албаны болон үндэсний хувцастай байна.

Тав. Сүлдийн өргөөнд ороход хориглох зүйлс

5.1. Сүлдийн өргөөнд энэ журмын 1.2-т зааснаас өөр зочин оруулахыг хориглоно.

5.2. Сүлдийн өргөөнд эмэгтэй хүн оруулахыг хориглоно.

5.3. Сүлдийн өргөөнд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, сэтгэцийн хэвийн бус байдалтай хүн оруулахыг хориглоно.

5.4. Сүлдийн өргөөнд тамхи татах, чанга ярих, өргөөний эд зүйлсэд гар хүрэх, гар утсаар гэрэл зураг авах, видео бичлэг хийхийг хориглоно. ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бөгөөд Их сүлдэчийн зөвшөөрснөөр зөвхөн мэргэжлийн гэрэл зурагчин зураг авч болно.

5.5. Бүх Цэргийн Их Хар Сүлдээс адис авсан зочин хадаг, мөнгө зэргийг өргөхийг хориглоно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Сүлдийн өргөөг нээж зочныг оруулах, гаргах, өргөөний ашиглалт, засвар, үйлчилгээ, цэвэрлэгээг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бөгөөд Их сүлдэчээс тусгайлан томилгоожсон элч сүлдийн сүлдэч, Сүлдийн хамгаалагчийн хяналт дор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газар, БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн холбогдох албан тушаалтан хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Сүлдийн өргөөнд зочин оруулах үед нэмэлт хамгаалалт, хүндэт харуул гаргана.

6.3. Бүх Цэргийн Их Хар Сүлдийн өргөөний түлхүүрийг ЗХЖШ-ын шуурхай жижүүрийн байранд хадгална.

6.4. Журмын хэрэгжилтэд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бөгөөд Их Хар Сүлдийн сүлдэч хяналт тавина.

---oO---